

ЗӨВЛӨМЖ

2017.11.02

Эрх зүйн баримт бичиг:

- Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 /УИХ-ын 2016 оны 19-р тогтоол/
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль /2015.11.26/
- Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоол “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”
- Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”
- Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр /УИХ-ын 2016 оны 45-р тогтоол/
- Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /ЗГ-ын 2016 оны 121-р тогтоол/
- Дархан-Уул аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр /Дархан-Уул аймгийн ИТХ-ын ээлжит бус Гуравдугаар хуралдааны 2016 оны 3/03-р тогтоол/
- Дархан-Уул аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /Дархан-Уул аймгийн Засаг даргын 2016 оны А/477 дугаар захирамж/
- Дархан-Уул аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэхээр дэвшүүлсэн зорилт /Дархан-Уул аймгийн ИТХ-ын 7 дахь удаагийн 2016 оны 5/02-р тогтоол¹

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын 9.1-д заасны дагуу аймгийн Засаг даргын Тамгын газар нь тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг журмын 8 дугаар хавсралтын дагуу гаргаж Засгийн газрын хэрэг эрхлэх газарт заасан хугацаанд нь хүргүүлнэ.

¹ Аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэхээр дэвшүүлсэн зорилтууд:

1.Төрийн албан хаагчдыг чадавхижуулах, ёс зүй, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх замаар Төрийн албаны хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг сайжруулна.
2.Шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэд, төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлнэ.

Энэ хүрээнд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээн дэх агентлагууд “2017 оны үйл ажиллагааны үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан”-г тайлагнах загвар, зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн хүрээнд аймгийн Засаг даргын баталсан 2017.07.04-ны өдрийн “Зөвлөмж”-ийг хэрэгжүүлж ажиллах,
2. Байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний баг нь байгууллагаас тайлагнаж байгаа бүх бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд журмын дагуу /өөрийн/ үнэлгээг өгч, байгууллагын удирдлагын хурлаар хэлэлцүүлэн, баталгаажуулж ЗДТГ-ын бодлогын хэлтэстээ албан бичгээр хүргүүлэх,
3. Төрийн албан хаагч бүр аливаа хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн, үйл ажиллагааны үнэлгээний тайлангийн хэрэгжилтийг тайлагнахдаа:

а/ бодит, үнэн зөв мэдээллийг оруулах

б/ хүрэх буюу зорилтот түвшинтэйгээ уялдуулж тайлагнах

в/ шаардлагатай тохиолдолд нотлох фото зураг, материалыг PDF хэлбэрээр хавсаргаж ирүүлэхийг тус тус зөвлөж байна.

Жич: “2017 оны үйл ажиллагааны үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан”-г тайлагнах загварт тусгагдсан Дөрөв.“ТЭРГҮҮН ТУРШЛАГА, ОНЦЛОГ АЖИЛ”, Тав.“СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛУУД” нь 5 хүртэлх оноог нэмэлтээр тооцуулах боломжтой болно.



ХШҮДАХ

